



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

“Стандарт инвестмент ҮЦК” ХХК-ийн
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2, 63 дугаар зүйлийн 63.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-ын 8.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Стандарт инвестмент ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлийг арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг “Стандарт инвестмент ҮЦК” ХХК /Ч.Жаргал/-д анхааруулсугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГТ ГҮЙШӨТГЭГЧИ,
ДЭД ДАРГА  Э.БАТБОЛД

